

**ЗАВХАН АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
ТУСЛАХ ТҮШМЭЛИЙН АНГИЛЛЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН АЖЛЫН БАЙРНЫ
СУЛ ОРОН ТООГ НӨХӨХ ИРГЭДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТӨРИЙН АЛБАНЫ МЭРГЭШЛИЙН
ШАЛГАЛТЫН ТУХАЙ**

Нэг. Мэргэшлийн шалгалтын зорилго

Завхан аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог анх орох иргэдээс өрсөлдүүлэн шалгаруулж нөхөхөд төрийн албаны мэргэшлийн шалгалтын зорилго оршино.

Хоёр. Мэргэшлийн шалгалтын бүртгэл, зардал

Зарлагдаж буй сул орон тоонд тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан, энэ албан тушаалд ажиллахыг хүссэн иргэнийг бүртгэнэ.

Тус аймгийн нутгийн захиргааны байгууллагаас зарласан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх иргэнийг сонгон шалгаруулах мэргэшлийн шалгалтад орохыг хүссэн иргэдийг Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар дээр **2018 оны 12 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд 10.00-17.00** цагийн хооронд бүртгэнэ.

Мэргэшлийн шалгалтад орох иргэн шалгалттай холбогдох зардлыг өөрөө хариуцах бөгөөд мэргэшлийн шалгалт өгөх иргэний шалгалтын үйлчилгээний зардал **6000** төгрөг байна.

Гурав. Бүртгүүлэх иргэн дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ

Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албан хаагчийн анкетыг маягт N1-ийн дагуу бүрэн бөглөсөн байх);

Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;

Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн эх хувийг хуулбарын хамт;

Иргэний үнэмлэхний эх, хуулбарын хамт;

“4 x 6”-гийн хэмжээний цээж зураг 2 хувь;

Ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт /Нийгмийн даатгал, хөдөлмөрийн дэвтэр/-ийн эх хувийг хуулбарын хамт

Шалгалтын үйлчилгээний төлбөр

Дөрөв. Шалгалтын хуваарь

2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр шалгалтыг доорхи байдлаар зохион байгуулна.

1. Ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох шалгалт

2. Ур чадварын түвшин тогтоох шалгалт /Ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох шалгалтад тэнцсэн иргэн өгнө/

3. Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох шалгалт /Ур чадварын түвшин тогтоох шалгалтад тэнцсэн иргэн өгнө/

Шалгалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам, заавар”-тай танилцаж, авна уу.

Шалгалт авах газар, хуваарийг бүртгүүлсэн иргэдийн тооноос хамааруулан **2018 оны 10 дугаар сарын 13 -ны өдрийн 16.00** цагт Засаг даргын Тамгын газар дээр мэдээлнэ.

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгөх иргэд **Иргэний үнэмлэхтэйгээ** ирнэ.

Тав. Мэдээлэл лавлагаа

Мэргэшлийн шалгалттай холбоотой асуудлаар тус аймгийн ЗДТГ-ын 70462801, 98826166 дугаарын утсаар холбогдож лавлагаа авч болно.

Шалгалт өгөх иргэдийн анхааралд:

1990 оны 05 дугаар сарын 06-ны өдөр болон түүнээс хойш төрсөн иргэн хуульд заасан цэргийн жинхэнэ алба хаах үүргээ биелүүлээгүй бол төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад оруулахгүй.

ЗАВХАН АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТОО БОЛОН
АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Д/д	Захиалга өгсөн байгууллага	Нэгжийн нэр	Албан тушаалын				Ажлын байранд тавигдах шаардлага					
			Ангилал	Нэр	Хариуцсан асуудал	Орон тоо	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	Ур чадвар	Тусгай шаардлага
ТУСЛАХ ТҮШМЭЛ												
1	Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа		T3-2	Байгаль хамгаалагч	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	1	Дээд боловсролын “Бакалавр” болон түүнээс дээш зэрэгтэй байх	Экологич, байгаль хамгаалал, эрх зүй	Байгаль шинжлэл, төрийн удирдлага, байгаль орчны чиглэлээр тусгайлсан сургалтанд хамрагдсан байх	Харгалзахгүй	Компьютерийн хэрэглээний программ дээр ажиллах чадвартай, Асуудал шийдвэрлэх, боловсруулах, зохион байгуулах, багаар ажиллах, бусдыг манлайлах, зөрчлийг хянан шийдвэрлэх чадвартай	Хариуцан хамгаалж буй нутаг дэвсгэрт амьдарч ажиллах, хууль ёсыг дээдлэх зарчмыг эрхэмлэх, үнэнч шударга байх, төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлах, бусдын нөлөөнд автахгүй байх
2	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Асгат сумын Засаг даргын Тамгын газар	T3-2	Байгаль хамгаалагч	Байгаль орчин	1	Тусгай дунд болон түүнээс дээш боловсролтой байх	Байгаль орчны чиглэлээр болон бусад	Байгаль орчны чиглэлийн хууль тогтоомжуудыг судалсан байх	Харгалзахгүй	Байгаль орчны тухай хууль тогтоомжуудыг бүрэн судалж, заалтуудыг сахин биелүүлэх чадвартай, иргэн, олон нийттэй харилцах ур чадвар эзэмшсэн, байгаль орчны доройтлыг	Ёс зүйн хэм хэмжээг сахих, эрх мэдлийнхээ хүрээнд бусдад нөлөөлөх чадвартай байх Орчноо мэдэрч зөв үнэлэх мэдлэгтэй байх Багаар ажиллах, хариуцлага хүлээх чадвартай байх

											зогсоох, сааруулах арга замыг мэддэг	
3	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Баянтэс сумын Засаг даргын Тамгын газар	T3-2	Байгаль хамгаалаг ч	Байгаль орчин	1	Тусгай дунд болон түүнээс дээш боловсролт ой байх	Байгаль орчны чиглэлээр болон бусад	Байгаль орчны чиглэлийн хууль тогтоомжу удыг судалсан байх	Харгалзах гүй	Байгаль орчны тухай хууль тогтоомжууд ыг бүрэн судалж, заалтуудыг нь сахин биелүүлэх чадвартай, иргэн, олон нийттэй харилцах ур чадвар эзэмшсэн, байгаль орчны доройтлыг зогсоох, сааруулах арга замыг мэддэг	Ёс зүйн хэм хэмжээг сахих, эрх мэдлийнхээ хүрээнд бусдад нөлөөлөх чадвартай байх Орчноо мэдэрч зөв үнэлэх мэдлэгтэй байх Багаар ажиллах, хариуцлага хүлээх чадвартай байх
4	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Яруу сумын Засаг даргын Тамгын газар	T3-2	Байгаль хамгаалаг ч	Байгаль орчин	1	Тусгай дунд болон түүнээс дээш боловсролт ой байх	Байгаль орчны чиглэлээр болон бусад	Байгаль орчны чиглэлийн хууль тогтоомжу удыг судалсан байх	Харгалзах гүй	Байгаль орчны тухай хууль тогтоомжуу дыг бүрэн судалж, заалтуудыг нь сахин биелүүлэх чадвартай, иргэн, олон нийттэй харилцах ур чадвар эзэмшсэн, байгаль орчны доройтлыг зогсоох, сааруулах арга замыг	Ёс зүйн хэм хэмжээг сахих, эрх мэдлийнхээ хүрээнд бусдад нөлөөлөх чадвартай байх Орчноо мэдэрч зөв үнэлэх мэдлэгтэй байх Багаар ажиллах, хариуцлага хүлээх чадвартай байх

										мэддэг		
5	Нөмрөг сум	Нөмрөг сумын Засаг даргын Тамгын газар	T3-3	Төсөв, төрийн сангийн мэргэжил тэн	Төсөв, төрийн сан	1	Дээд боловсролтой бакалавр зэрэгтэй байх	Санхүүч, эдийн засагч, нягтлан бодогч	Эдийн засагч, нягтлан бодогч мэргэжлээр мэргэшсэн, хэрэглээний программуудыг эзэмшсэн байх	Харгалзахгүй	Манлайлан удирдах, зохион байгуулах, хүнтэй харьцах эв дүйтэй, компьютерийн мэдлэг, чадвартай, гадаад хэлний зохих мэдлэгтэй	Орчноо зөв мэдрэх, зөв үнэлэх, олон нийттэй харьцах, баг бүрдүүлэх, багаар ажиллах чадвартай байх
6	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Завханмандал сум ЗДТГазар	T3-3	Завханмандал сумын газрын даамал	Газрын тухай багц хууль, холбогдох бусад эрхийн актууд болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан газрын харилцааны чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын чанартай арга хэмжээний хэрэгжилтийг хангах	1	Газар зохион байгуулалтын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Газар зохион байгуулагч, инженер, газрын кадастрын инженер, геодези инженер, газрын үнэлгээ	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслөөр мэргэшсэн байх	Харгалзахгүй	Мэргэжлийн болон хэрэглээний програм дээр ажиллах чадвартай, Англи хэлний зохих мэдлэгтэй, албан бичиг боловсруулах, багаар ажиллах чадвартай, мэргэжлээр ээ мэргэшсэн.	Оюун санаа бие бялдрын хувьд эрүүл байх, хууль журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг чанд сахидаг, нууц хадгалах чадвартай, идэвхи санаачлагатай, харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай байх. ажлын шаардлагаар илүү цагаар ажиллах, томилолтоор ажиллах, орчноо мэдрэх, хүнийг танин мэдэх, зөв үнэлэх, үнэнч шударга, шуурхай ажилтан байх
7	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Баянхайрхан сум ЗДТГазар	T3-3	Баянхайрхан сумын газрын даамал	Газрын тухай багц хууль, холбогдох бусад эрхийн актууд болон Засгийн	1	Газар зохион байгуулалтын чиглэлээр бакалавр	Газар зохион байгуулагч, инженер, газрын кадастрын	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг	Харгалзахгүй	Асуудал дэвшүүлэх, журам, заавар, аргачлалыг хэрэгжүүлж,	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиу, нууц хадгалах, харилцааны соёл эзэмшсэн, үнэнч

					газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан газрын харилцааны чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын чанартай арга хэмжээний хэрэгжилтийг хангах		болон түүнээс дээш боловсролт ой	инженер, геодези инженер, газрын үнэлгээ	төслөөр мэргэшсэн байх		үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, компьютерийн хэрэглээний болон газар зүйн мэдээллийн системийн программ хангамжийг эзэмшсэн байх, Англи хэлний мэдлэгтэй байх	шударга, шуурхай ажилтан байх, илүү цагаар ажиллах
8	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Яруу сум ЗДТГазар	ТЗ-3	Яруу сумын газрын даамал	Газрын тухай багц хууль, холбогдох бусад эрхийн актууд болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан газрын харилцааны чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын чанартай арга хэмжээний хэрэгжилтийг хангах	1	Газар зохион байгуулалтын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролт ой	Газар зохион байгуулагч, инженер, газрын кадастрын инженер, геодези инженер, газрын үнэлгээ	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслөөр мэргэшсэн байх	Харгалзах -гүй	Асуудал дэвшүүлэх, журам, заавар, аргачлалыг хэрэгжүүлж, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, компьютерийн хэрэглээний болон газар зүйн мэдээллийн системийн программ хангамжийг эзэмшсэн байх, Англи хэлний мэдлэгтэй байх	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, нууц хадгалах, харилцааны соёл эзэмшсэн, үнэнч шударга, шуурхай ажилтан байх, илүү цагаар ажиллах

9	Алдархаан сум	Алдархаан сумын ЗДТГ	ТЗ-3	Мал эмнэлэг, үржлийн тасгийн Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал	1	Дээд боловсролтой бакалавр зэрэгтэй байх	Малын их эмч мэргэжилтэй байх	Тухайн мэргэжлээр мэргэшсэн байх	Харгалзахгүй	Багаар ажиллах, бусдыг манлайлах чадвартай байх, төрийн залгамж халааг хадгалах, шударга байх	Шуурхай, хүнд сурталгүй, хариуцлагатай байх, хууль эрх зүйн зохих мэдлэгтэй, нэгдсэн дүн шинжилгээ хийх чадвартай, англи хэлний зохих мэдлэгтэй байх
---	---------------	----------------------	------	---	--	---	--	-------------------------------	----------------------------------	--------------	---	--

ТӨРИЙН АЛБАНЫ МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТЫН ТӨВ КОМИСС